

MICC ТЭМДЭГЛЭЛ

MICC.mn

2014 ОНЫ 2 ДУГААР САРЫН 20 (6)

14 хоног тутам гарна

MONGOLIA INTERNATIONAL CAPITAL CORPORATION — Монголын тэргүүлэх хөрөнгө оруулалтын банк

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭ

- Зэс, нүүрс, цайрын чиглэлээр ажилладаг Канадын "Тек Ресурс Лимитед" -ийн 2013 оны санхүүгийн Тайлан гарсан ба 9.38 тэрбум долларын орлого олсон нь 2012 оныхоос 9% буурсан үзүүлэлт ажээ. Нийт ашиг нь 2.4 тэрбум доллар болж өнгөрсөн оныхоос 1.1 тэрбумаар буюу 31%-иар буурсан байна.
- Рио Тинто компанийн 2013 оны 2-р хагасын санхүүгийн тайлан гарлаа. Хоёрдугаар хагаст цэвэр ашиг нь 3.67 тэрбум байна. Өнгөрсөн оны мөн үед 3.31 тэрбум долларын алдагталтай ажиллаж байсантай харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Мөн төмрийн хүдрээс олсон ашиг нь 6.6%-р өссөн байна.
- Оюу Толгой төслийг хэрэгжүүлэгч "Turquoise Hill Resources" компанийн хувьцааны үнэлгээ өнгөрсөн 7 хоногт 8 хувиар буурч, NYSE дээрх үнэлгээ нь 3.14 доллар болсон. Энэ нь тус компанийн гаргасан мэдэгдэлтэй холбоотой юм. Уг мэдэгдэлд Монголын засгийн газар Рио Тинто компанийн хоорондох шийдвэрлэх асуудлыг ирэх сарын 31-ээс өмнө буюу зээл олгох баталгааны хугацааны өмнө амжиж шийдвэрлэхгүй бол далд уурхайн ажил дахин хойшилж магадгүйг анхааруулжээ.
- ЕСБХБ-аас санхүүжүүлэн Адам Смит Интернэшнл байгууллагын хэрэгжүүлж буй Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын сангийн (ОУИТБС) хэрэгжилтийг дэмжих төслийн хүрээнд зөвлөлдөх уулзалтыг энэ сарын 18-нд УБ зочид буудалд зохион байгуулах гэж байна.
- Эрдэс баялгийн салбарын өрсөлдөх чадвар, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх зорилго бүхий "Эрдэс баялаг 2025" олон нийтийн хэлэлцүүлэг эхэллээ.
- Оросын нүүрсний экспорт нэмэгджээ. 12.6 хувиар өсч 117,83 сая тоннд хүрчээ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корп.

Эрдэнэ	Ресурс	компанийн
Алтан	нар	хайгуулын
ордын	нөөцийг	төсөл
	давах	Бороогийн
		боломжтой

Алтан нар төслийн сүүлийн 3 шатны суваг малталтын ажлаар газрын гадаргууд ойрхон алт, мөнгө, полиметаллын өндөр агуулга хүдэржилтийг 8 хавтгай км талбайг хамтарсан 5 тусдаа бүсэд илрүүлээ. Нээлтийн бүсэд өмнөх өрөмдлөгөөр ач холбогдол бүхий алт-полиметаллын хүдэржилтийг 450м х 150м хэмжээтэй талбайд тогтоосон бөгөөд энэ талбайн 250 метрийг хамарч 4 суваг малтсан. Эдгээр 4 сувгийн 3-т нь 44-өөс 50 гаруй метрийн зузаантай 1 гаруй г/т алтны дундажагуулгатай Алт-мөнгөний эрдэсжилттэй штокверк брекчийн өргөн бүс тодорхойлогдсон ба өндөр агууламжтай зузаан интервал нь 2.4-өөс 3.0 г/т алт, 8-аас 20 г/т мөнгө дагалдсан 11-ээс 15 метр хэмжээтэй байна. Одоогоор Эрдэнэ 5 талбайд өндөр агуулгатай алтны эрсдэлжилт гадаргууд илрүүлээд байна.

Өндөр агууламж бүхий эрдэсжилттэй гадаргуун бүх илэрлүүд нь 5.5 км урт сунасан талбайг хамарч байгаа бөгөөд энэхүү талбай цаашид томрох үндэслэл өндөр. одоогийн байдлаар Алтан нар төслийг бусад алтны ордуудтай харьцуулахад эрт байгаа боловч Сентерра Гоулд компанийн Бороогийн алтны төсөлтэй харьцуулбал нөөцийн хувьд давамгайлах боломжтой гэж бид үзэв. Бороогийн алтны төсөл нь гадаргуун уртаар 2.5 км-т 2.5 г/т дундаж алтны агууламж бүхий 1.5 сая унц алтны нөөцтэй байсан юм.

Эрсдлийн хүчин зүйлс: Монгол улсын гадаадын хөрөн суулагчдад хандуулах хууль эрх зүйн нөхцөл байдал нь эерэг хандлага руу шилжиж байгаа бөгөөд Монгол дахь гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, сөрөг хандлагуудыг бууруулахад Монгол Улсын Засгийн Газар болон УИХ анхаарал хандуулах болсон. Сүүлийн 6 сарын хугацаанд Монгол УИХ өнгөрсөн жил гадаадын шууд хөрөнгө оруулалтыг 50%-иар бууруулахад нөлөө үзүүлсэн хэд хэдэн хууль тогтоомжуудыг зохих журмын дагуу өөрчилсөн билээ.

Эрдэнэ Ресурс компанийн хувьцааны судалгааг 2013 онд хийж олон нийтэд нийтэлж байхдаа олон улсын ижил төстэй компаниудтай харьцуулах судалгааны үндсэн дээр 0.31 канад

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОДРУУЛГА



долларын үнэ хүрэх боломжтой гэж үзэж байсан бөгөөд энэхүү үнэд хүрэх боломжтой гэж үзсэн хэвээр байна.

"ЭНЕРЖИ РЕСУРС" ЗАМ ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨРӨӨ АВАВ

"Эрдэнэс МГЛ" компани "Энержи Ресурс" компанид 116 сая долларын нөхөн төлбөрийг төлөхөөр болжээ. талууд энэ сарын 12-нд Зам шилжүүлэх тухай гэрээг байгуулсан байна. Засгийн газрын тогтоолоор Тавантолгой-Гашуун Сухайт чиглэлийн 245 км авто зам, Гашуунсухайт боомтыг "Эрдэнэс МГЛ" компанид шилжүүлэхээр болсон. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн автозамыг "Энержи Ресурс" компани өөрийн хөрөнгөөр бөржж байгуулсан юм. Энэ дагуу "Энержи Ресурс" компанид 15708 тэрбум төгрөг буюу 90.3 сая долларын замын нөхөн төлбөр төлж, уг замыг "Эрдэнэс МГЛ" компани худалдаж авч байгаа юм.

Зам тээврийн яам, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам болон "Эрдэнэс МГЛ" компанийн төлөөлөл бүхий Ажлын хэсэг нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосон байна.

Түүнчлэн 2012 онд Гашуунсухайт боомтын хоёр урсгалтай замыг өргөтгөж, 10 урсгалтай болгосон. Боомтын өргөтгөлийн хөрөнгө оруулалтыг "Энержи Ресурс" компани хийсэн бөгөөд дээрх төлбөрийг замын төлбөрийн хамт төлөхөөр болжээ. 116 сая долларын санхүүжилтыг Хөгжлийн банк "Эрдэнэс МГЛ" компанид зээлж байгаа аж. "Энержи Ресурс" компанид нөхөн төлбөрийг шилжүүлэлгүй удааширсан нь Хөгжлийн банкнаас авах зээлийн хүү дээр тохиролцож чадахгүй байсантай холбоотой юм. Хөгжлийн банкны зээлийн хүү 4% гэж тохирсноор санхүүжилт авах боломжтой болжээ.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн автозамыг "Эрдэнэс МГЛ" компани шилжүүлэн авснаар нүүрс тээвэрлэлтын зардал буурах юм байна. Албан ёсоор зам ашиглалтын үнийг тогтоогоогүй байгаа ч нэг тонн нүүрсийг 1.5 ам.доллараар тогтоож магадгүй талаар ярилцаж байгаа ажээ.

"МЕРЕКС" КОМПАНИ МХБ ДЭЭР ИРО ХИЙНЭ

Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолыг үндэслэн МХБ "Мерекс" (MSE: MRX) ХК-ийн олон нийтэд санал болгож буй нэг бүр нь 100 төгрөг бүхий нэрлэсэн үнэ бүхий 65,005,000 ширхэг хувьцааг МХБ-ийн үнэт цаасны жагсаалтад бүртгэсэн.

Үнэт цаас гаргагч Мерекс ХК нь 2012 онд гадаад худалдаа, барилгын материалын худалдааны чиглэлээр үүсгэн байгуулагдсан ба УБ хотын СХД-ийн нутаг дэвсгэрт өөрийн эзэмшлийн 2 га газартай. БНСУ-д бүтээгдсэн, цагт 150 м3 бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай TW-2500 маркийн бетон зуурмагийн үйлдвэртэй. Үнэт цаас гаргагч нь 2014-2017 онд нийт 513.2 мян.м3 бетон зуурмаг үйлдвэрлэн, 82.05 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөсөн ба энэ хугацаанд нийт 79 ажлын байрыг бий болгож, 11.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, улсын төсөвт 1.8 тэрбумтөгрөгийн татварын орлого оруулхаар байна.

Үнэт цаас гаргагч нь бетон зуурмагийн үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлж, үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтаар 3.9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг бүрдүүлсэн ба цаашид үйлдвэрлэлийг дэлгэрүүлж, бизнес төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлж, компани үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлэхээр 2.6 тэрбум төгрөгийг зах зээлээс татан төвлөрүүлэх буюу компанийн нийт хувьцааны 40% болох 26,000,000 сая ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгох юм.

"Мерекс" компанийн хувьцааны захиалгыг 2014 оны 3-р сарын 3-ны өдрөөс авч эхлэх ба нийт 7 хоног үргэлжилнэ.



THIS IS THE MICC JOURNAL, A BI-MONTHLY FINANCE AND ECONOMICS PAPER
PUBLISHED BY MICC, THE LEADING INVESTMENT CORPORATION IN MONGOLIA.

MICC хөрөнгө оруулалтын корпорацийн тухай

MICC нь компанийн санхүүжилт, үнэт цаасны арилжаа,
судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг цогц үйлчилгээг

MICC ТЭМДЭГЛЭЛ – ийн тухай

Хоёр долоо хоног болгон гарах энэ бяцхан сонин
танд эдийн засаг, санхүүгийн мэдээлэл өгөх
боловч хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөхгүй.

Таны ЭРСДЭЛ таны ХАРИУЦЛАГА.

Эрхлэгч: Э. Оюу.

2014/02/20

Мэдээллийн эх сурвалж:
Bloomberg, Монголын
Хөрөнгийн Бирж, MSCI Barra,
OECD.